

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн жинхэнэ албан хаагчийг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:

- Төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- Зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- Зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшнийг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
- Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–с татан авах/.

Материал хүлээн авах:

- Хугацаа: 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 17:00 цагаас 01 дүгээр сарын 24-ны өдрийн 17:00 цаг хүртэл
- Хүлээн авах хаяг: info@nsuq.ub.gov.mn цахим шуудангаар
- Холбоо барих утас: 11-321529, 88470331

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ТУШААЛЫН СУЛ ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ, СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТУХАЙ
(Шилжин ажиллах)

БАЙГУУЛЛАГА: НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

№	Дотоод нэгж	Албан тушаал	Орон тоо	Албан тушаалын		Албан тушаалд тавигдах тусгай шаардлага		
				Төрөл	Ангилал зэрэглэл	Боловсрол	Мэргэжлийн индекс	
1	ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТЭС	Төлөвлөлт, тайлагналт, мэдээлэл технологи, цахимжилтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	1	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-7	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.	Эрх зүй (0421) Урлаг (021) Мэдээлэл, харилцаа холбооны технологиуд (061) Менежмент ба удирдахуй (041303-041307)	